



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар A/190

Номгон

Г“Аймаг, сум, баг, хороо, хөршөөрөө хамтдаа  
сэг зэмгүй байя ” уриатай сэг зэм устгал,  
халдвартгүйтгэлийн ажил арга хэмжээг зохион  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах тухай” ХХААХҮС-ын 2024 ны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар болон “Халдвартгүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай” Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн A/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны сэг, зэм устгалын ажил арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Мал, амьтны сэг, зэм устгал, халдвартгүйтгэлийн ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний хооронд чанартай зохион байгуулж хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3.Мал, амьтны сэг зэм булах цэгийн байршлыг тогтоон арга зүйгээр хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



52401042 :

Аймгийн Засаг даргын орлогын дугаар сарын  
...ны өдрийн ... дугаар захирамжийн  
1 дугаар хувь



МАЛ, АМЬТНЫ СЭГ, ЗЭМ УСТГАЛЫН АЖИЛ АРГА  
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАХ  
АЖЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батсуурь

Засаг даргын орлогч

Гишүүд:

Ж.Алтангэрэл

Онцгой байдлын газрын дарга

У.Балжинням

Хүнс, хөдөө аж ахийн газрын даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Э.Ганзориг

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Б.Мөнхбаяр

Цагдаагийн газрын дарга

Н.Энхжаргал

Эрүүл мэндийн газрын дарга

Сумдын болон багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга

Л.Оюун-Эрдэнэ

Мал эмнэлгийн газрын дарга

ооо



Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар сарын  
...ны өдрийн ... дүгээр зохицалтад дүгээр зохирамжийн  
2 дугаар хувьраат

## УДИРДАМЖ

мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны  
цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийн ажил арга  
хэмжээг зохион байгуулах тухай

### Нэг. Зорилго

Энэхүү удирдамжийн зорилго нь хүн, малын халдварт, гоц халдварт өвчин  
гараахаас урьдчилан сэргийлж, өвөлжилт, хаваржилтын хүндэрэл, отор нүүдлийн  
замд хорогдсон малын хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, өвөлжөө, хаваржааны  
хашаа хороо, өтөг бууц, худаг, уст цэг, бэлчээрийг цэвэрлэж, халдвартгүйтгэх  
ажлыг орон даяар эрчимтэй зохион байгуулахад оршино.

### Хоёр. Хугацаа

Урьдчилан сэргийлэх халдвартгүйтгэлийн арга хэмжээг 2024 оны 4 дүгээр  
сарын 1-нээс эхлэн улсын хэмжээнд хэрэгжүүлж, мал, амьтны хүүр. сэг зэмийн  
устгал, орчны цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг 2024 оны 06 дугаар  
сарын 01-ний өдрийн дотор улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд зохион  
байгуулж ажиллах;

### Гурав. Хэрэгжүүлэх бүрэлдэхүүн

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын тамгын газар, багийн Засаг  
дарга нар, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, тасаг, мал эмнэлгийн  
үйлчилгээний нэгжийн малын эмч нар, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжтэй  
хамтран гүйцэтгэнэ.

### Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймаг, сумын Засаг даргын захирамжаар сэг зэмийг цуглуулах, булах  
ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сумын удирдах ажилтнаар ахлуулан  
томилгоожуулж, ажлын хэсгийн явах маршрут, зураглалыг баг, багийн нутаг  
дэвсгэрээр гарган, шаардагдах шатахуун, зардлын тооцоог гаргана.

2. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгахад оролцох ажиллах хүн хүч, унаа,  
тээврийн хэрэгсэл, шаардагдах халдвартгүйтгэлийн бодис, халдвартгүйтгэлийн  
хувцас, багаж хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэж, уг ажилд төрийн болон орон нутгийн  
байгууллага, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр татан

2.

оролцуулна.

3.Халдвартгүйтгэлийн үйл ажиллагаанд шаардлагатай бодис, уусмалын тооцоог гаргаж, татан авах, малын эм, эмнэлгийн хэрэгсэл, халвар хамгааллын хувцас, халдвартгүйтгэлийн бодис, техник, тоног төхөөрөмжийн судалгааг үндэслэн нөөц бурдүүлсэн байна.

4.Булах ажлыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг сайтар хангах, хүн мал, амьтанд халвар дамжихаас сэргийлэн булах ажлын зохион байгуулалт сайтай, түргэн шуурхай гүйцэтгэх, байгаль орчинд ямар нэг хор аюулгүй байх нөхцөлийг тооцож ажиллах.

5.Сумын нэг багийн нутаг дэвсгэрт дунджаар 3 устгалын цэг байхаар тооцно.

6.Гадаад орчны дулаан хэт нэмэгдэж, цас хайлж, сэг зэм илжирч муудахаас өмнө булах цэгийг тогтоож, малчдын цахим группээр дамжуулан булах цэгийн байршлын мэдээллийг хүргэж, сэг зэмээ тээвэрлэх боломжтой малчдыг товлосон цэгт цуглуулах талаар зар хүргэж ажиллах.

7.Булах газрыг байгаль орчны улсын байцаагчийн тогтоосон цэгт сонгож, сэг зэмийг цуглуулна. Цуглуулсан сэг зэмийг 4x5x4 метр хэмжээтэй ухаж, бэлтгэсэн нүхэндээ сэг зэмийн гэдсийг хагалж хийнэ /ойролцоогоор 1200- 1300 богийн сэг зэм орохоор/. сэг зэмийг үелүүлэн чигжиж хийнэ.

8.Нүхний амсраас 50 см доош байхаар сэг зэмээ хийж, дээр нь халдвартгүйтгэлийн бодис / хлорын шохой цацаж/ цацаж, шороогоо хийж булшилна.

9.Шороог нүхний амсраас дээш 1,5 метрээс багагүй байхаар овоолж, хөрсөөр хучна./Үүний дараа сэг зэм байсан болон орчны хөрсийг найруулсан халдвартгүйтгэлийн уусмалаар шүршиж халдвартгүйтгэнэ/.

10.Булшилж устгасан цэгийн эргэн тойрон хашлага хийж, "АНХААР" гэсэн анхааруулга тэмдэг байрлуулж, сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

11.Малчдын өвөлжөө, хаваржааны хашаа хороо, өтөг бууц, малын тоног хэрэгсэл, худаг, уст цэг, бэлчээр, булшилж устгах цэгийн орчны хөрсний халдвартгүйтгэлийг сумын МЭТ-ийн заавар зөвлөмжийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хэрэгжүүлнэ.

12.Урьдчилан сэргийлэх халдвартгүйтгэлийн арга хэмжээнд Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанар, стандартын шаардлага хангасан, хүн,

3.

малын эрүүл мэнд, байгальд хор нөлөөгүй халдвартгийтгэлийн бодис хэрэглэнэ.

13.Булах ажиллагаа дуусмагч сэг зэм тээвэрлэсэн автомашин, тоног төхөөрөмжийг цэвэрлэн, халдвартгуйжүүлэх бодисоор шүршиж халдвартгуйжүүлнэ.

14.Устгалд оролцсон багийн /ажлын хэсгийн/ гишүүд өмссөн хамгаалах хувцас хэрэглэлээ тайлж халдвартгийтгэл хийлгэж , устгана.

ооо



Аймгийн Засаг даргын ..... онд 03 дугаар сарын 27-ны  
өдрийн 41190 дуээрсах грамжин Здугаар хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ,  
МАЛ, АМЬТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНД ХЯНАЛТ ТАВИХ,  
СЭГ ЗЭМ УСТГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж, албан хаагч	Хамтран хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх хугацаа
1	2	3	4	5
1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлгийн халдвартгүйтгэлийн ажлыг зохион байгуулах;	Аймаг, сумдын ЗДТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс,	03 сар, 04 сар
2	Мал, амьтны сэг зэмийг устгах, халдвартгүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээвэр болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэн зорилго ач холбогдлыг өргөн сурталчлах;	Аймаг, сумдын ЗДТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар,	03 сар, 04 сар
3	Харьяалах нутаг дэвсгэртээ отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоож, хяналт тавих, удирдлагаар хангах;	Аймаг, сумдын ЗДТГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	03 сар, 04 сар
4	Аймаг, сумын Засаг дарга нар төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй, нэгж байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, мэргэжлийн анги томилж, ажиллах боломжоор хангах, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд холбогдох хууль, журам, заавар, стандартын мөрдөж таслан зогсоох;	Аймаг, сумдын ЗДТГ	ХБТХОХ, МЭГ, ОБГ, ЦГ, ХХААГ,	03 сар, 04 сар
5	Зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг устгах, малын хашаа, хороог цэвэрлэж халдвартгүйтгэл хийх "Орчны цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийн сарын аян"-ыг 2024 оны 03 дүгээр сарын 20-ны өдрөөс нэгдсэн байдлаар зохион байгуулах;	Аймаг, сумдын ЗДТГ	ХБТХОХ,, МЭГ, ОБГ, ЦГ, ХХААГ, БОАЖГ	03 сар, 04 сар

1	2	3	4	5
6	Аяныг хүрээнд ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээний хэлбэрээр зохион байгуулах;	Аймаг сумдын ЗДТГ	ХБТХОХ, МЭГ, ОБГ, ЦГ, ХХААГ, БОАЖГ, НБХ	03 сар, 04 сар
7	Аж ахуйн түвшинд халдвараас хамгаалах халдвартгүйтгэлийн арга хэмжээнд шаардагдах халдвартгүйтгэлийн бодис, амны хаалт, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бэлтгэх, хангах, нөөц бүрдүүлэх;	Аймаг сумдын ЗДТГ	МЭГ, ОБГ	03 сар, 04 сар
8	Улсын болон тусгай хэрэгцээний отрын бүс нутагт отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх малын шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, хяналт тавих үүрэг бүхий хяналтын цэгүүдийг ажиллуулах, үүрэгжүүлэх;	Аймаг сумдын ЗДТГ	МЭГ, ОБГ, ЦГ, ХХААГ,	03 сар, 04 сар
9	Малын бэлчээр, тариалангийн талбай, төв, орон нутгийн чанартай зам дагуу, гол, горхи, булаг шандын орчимд мал, амьтны хүүр, сэг зээнийг орхисон, хаясан мал бүхий иргэн, малчныг тогтоон буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцуулах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хариуцлага тооцох;	Аймаг сумдын ЗДТГ	ХБТХОХ,, ХХААГ, МЭГ, ОБГ, ЦГ	03 сар, 04 сар
10	Мал сүргийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, аймаг, сум дамжсан отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг эрчимжүүлж, сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх бүх талын арга хэмээг авч ажиллах;	МЭГ	СЗДТГ, ОБГ, ЦГ ХХААГ	Тухай бүрт
11	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнийг хууль эрх зүйн хүрээнд эрт илрүүлэх, шуурхай мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;	МЭГ	СЗДТГ, ОБГ, ЦГ ХХААГ	Тухай бүрт
12	Малын гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчинеэс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, малын гоц халдварт өвчнийг илрүүлж, дэгдэлтийг таслан зогсоох;	МЭГ	ХБТХОХ,, МЭГ, ОБГ	Тухай бүрт
13	Малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанар, аюулгүйн шаардлага хангасан халдвартгүйтгэлийн бодис, бэлдмэлийн нөөц бүрдүүлэн, хангамжийг сайжруулж ажиллах;	МЭГ	СЗДТГ, МЭГ, ОБГ	03 сар, 04 сар

1	2	3	4	5
14	Малын бэлчээр, тариалангийн талбай, төв болон гол зам дагуу, гол горхи, булаг шандны орчим, хүүр сэг зэмийг хаясан, орхисон, мал бүхий иргэн, малчныг тогтоон буруутай этгээдэд холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцох;	МЭГ	ХБТХОХ, МЭГ, ОБГ, ЦГ, ХХААГ, БОАЖГ	03 сар, 04 сар
15	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалдаг зоорь, агуулах, хүнсний зах, худалдааны төв, гахай, шувуу, амьтан тэжээдэг аж ахуйн нэгжүүдтэй халдвартгүйтгэл хийх гэрээ байгуулж хэрэгжилтийг хангах, хяналт тавих;	МЭГ	СЗДТГ, МЭТ, МЭҮН	Тухай бүрт
16	Отор нүүдэл хийх чиглэл, хугацаа, нутаг дэвсгэрийг тогтооход мал эмнэлгийн тархвар зүйн судалгаанд үндэслэн үнэлгээ, дүгнэлт өгөх, харьяалах нутаг дэвсгэрт отор нүүдлээр ирсэн мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг сонгох хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;	МЭГ	СЗДТГ, ЦГ, ХХААГ, МЭТ, МЭҮН	Тухай бүрт
17	Хээлтүүлэгч малын суурьт гоц халдварт, халдварт өвчний эмнэлзүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулж батапгаа гаргуулах;	ХХААГ	МЭГ, сумдын МЭТ, ХАА-н тасаг	Тухай бүр
18	Аймаг бүс нутаг дамжуулан хээлтүүлэгч мал тээвэрлэх, худалдаалах, нийлүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газраас зөвлөмж, мэдээлэл авч хамтран ажиллах, мал эмнэлгийн гэрчилгээ авах ажлыг олон нийтэд сурталчлах, мэдээлэх;	ХХААГ	МЭГ, сумдын МЭТ, ХАА-н тасаг	Тухай бүр

ооо